



ДОМОГТ ШАРЫН ГОЛ ХХК

“НОГООН ТӨГӨЛ ТӨСӨЛ”



Холбоо барих мэдээлэл:

- Утас: 99752819, 99616620
- И-мэйл: domogt_s@yahoo.com

Төслийн ...	Төслийн зорилго, зорилт, үр дүн
1. Төслийн ...	0.5 га талбайг моджуулах "Ногоон төгөл" төсөл
2. Төслийн ...	<p>Энэхүү төсөл нь Монгол Улсын цөлжилт, хөрсний доройтолтой тэмцэх, ойн хамгаалалтыг сайжруулах, унаган модны генийн санг хадгалсан ойн нөөц нэмэгдэх, ойжуулалтын ажлыг үр дүнтэй болгох зорилгоор 0.5- 1 га талбайг хашаажуулан шилмүүст болон цэцэгт навчит мод тарих үйл ажиллагааг хэрэгжүүлнэ. Төсөл нь "Тэрбум мод" үндэсний хөдөлгөөнтэй уялдаж, байгаль орчинд эерэг нөлөө үзүүлэхийн зэрэгцээ орон нутгийн иргэдийн оролцоог дэмжинэ.</p>
3. Төслийн зорилго:	<p>0.5-1 га хашаалсан талбайд шилмүүст болон навчит мод тарьж, арчлан ургуулсанаар сумын төв орчмын ногоон орчин нэмэгдүүлнэ, олон нийт, ард иргэдийн эрүүл мэнд, амьдрах таатай орчин бий болгоно, хөрсний эвдрэлээс сэргийлж, орчны агаарын бохирдлыг бууруулж сумын өнгө үзэмж цэвэр цэмцгэр болно.</p> <ul style="list-style-type: none"> • Шилмүүст мод тарих замаар мөнх цэвдэгийг хамгаалснаар хөрсний элэгдэл, салхины нөлөөг бууруулах, агаарын чанарыг сайжруулах. • Уур амьсгалын өөрчлөлттэй тэмцэхэд хувь нэмэр оруулах, Монгол Улсын "Тэрбум мод" хөдөлгөөнийг дэмжих • Хашаажуулалтаар малын хор хөнөөл, хүний буруутай үйл ажиллагаанаас талбайг хамгаалж, модны ургалтыг дэмжих, амьдралтын хувийг нэмэгдүүлэх. •
4. Төслийн зорилт	<ul style="list-style-type: none"> • 0.5 га талбайг хашаажуулж, өсвөр насны том бортоготой 50 ширхэг шилмүүст, болон цэцэгт навчит модны суулгац тарих. • Тариалсан модны амьдралтын хувийг 85%-иас дээш байлгах • Орон нутгийн иргэдийг сургалтад хамруулж, мод тарих, арчлах ур чадварыг нэмэгдүүлэх. • Уур амьсгалын өөрчлөлтийн эсрэг тэмцэлд хувь нэмэр оруулах, хүлэмжийн хийн ялгарлыг бууруулах.
5. Төслийн үндэслэл:	<ul style="list-style-type: none"> • Байгаль орчны нөхцөл: Монгол улсын газар нутгийн 76% нь цөлжилтөд өртсөн бөгөөд ой модны хамрах хүрээ нийт газар нутгийн ердөө 7-8%-ийг эзэлдэг. • Шилмүүст модны ач холбогдол: Нарс, шинэс, гацуур, хуш, жодоо, Монос, Голт бор • шилмүүст мод нь их хэмжээний фитонцид ялгаруулдаг, байгалийн агаар цэвэршүүлэгч, салхины хамгаалалт болж, хөрсийг бэхжүүлдэг. Мөнх ногоон өнгөтэй, Монгол улсад нэн

хэвэр ургамалд бүртгэгдсэн, хотын ногоон байгууламжинд үзэмж тоё, чимэг болдог, үнэт моднууд юм.

6. Төслийн байршил:

Дархан-Уул аймаг, Шарынгол сум, Хоккейчны хөшөөтөй төв талбай

7. Төслийн хэрэгжилтийн төлөвлөгөө:

7.1 Хашаажуулалт:

- **Төрөл:** Төмөр жижиг нүхтэй тороор өндөрлөж татах. торон хашаа / бат бөх чанарыг тооцов/
- **Хашааны хэмжээ:** 2м өндөр, 40 м урттай 4 талдаа, нийт 160 м
- **Материал:** Төмөр шон, төмөр тор, төмөр хаалга

Ажлын явц:

- Торон хашаа бэхлэх, хаалга суурьлуулах /1-2 хаалга/
- Хугацаа: 4 хоног

7.2 Талбай бэлтгэх:

- Талбайн өвс хадах /
- Хөрс шимжүүлэх
- Мод тарих нүх ухах

Хугацаа: Нийт 4 хоног

7.3 Тарьц суулгалт бэлтгэл

- **Модны төрөл ба тоо:**
Шинэс: 10
Гацуур: 10
Жодоо 10
Нарс 10
Монос 5
Голт бор 5

Суулгацын чанар: 8-10 настай, 80 см -2м өндөр бортоготой

7.4 Мод тарих: Технологи

- Нүхийг урьдчилан бэлтгэж, органик бордоо хийнэ.
- Суулгацыг бортгоноос гаргаж үндсийг гэмтээхгүйгээр тарина
- Тарилтын зай: 3-4м хоорондын зайтай, хэт шигүү тарихгүй
- Хугацаа: 5сарын 10-25 хооронд /хавар тарих нь амьдралтын хувь өндөр байна/

7.5 Усалгаа ба арчилгаа: Жилд 8 удаа услана

Арчилгаа: Эхний жилүүдэд арчилгаа маш чухал

- Хог ургамлыг цэвэрлэх
- Хортон шавжнаас хамгаалах
- Модны эргэн тойрон хөрс сийрүүлэх
- Салхинаас хамгаалсан тулгуур мод хийх

Хугацаа: Эхний 2 жил онцгой анхаарах шаардлагатай

8. Төсөл хэрэгжүүлэгч:

Домогт Шарынгол ХХК "Ойн мэргэжлийн байгууллага"

9. Төслийн хугацаа, нийт 2 жил, Төслийн нийт төсөвт өртөг : 12 200 000 ₮
төсөвт өртөг \төг \

10. Эрсдэл ба шийдэл:

Модны амьдралтанд нөлөөлөх мал ,амьтан, хүний хайхрамжгүй буруутай үйлдлээс хорогдол гарах, мод гэмтэх

- Чанартай тарьц сонгох, мэргэжлийн багаар ажиллах, эхний 2 жил арчилгааг сайн хийх

Хашаа гэмтэх, малын хөлд талхлагдах

- Бат бөх материал ашиглах, орон нутгийн иргэдтэй хамтран хяналт тавих

11. Төслийн үр дүн:

- Мөнх ногоон моднууд нь жилийн 4 улирал өнгө үзэмж гоё, цэвэр хүчилтөрөгч ялгаруулна, CO2 шингээнэ
- Сумын өнгө үзэмж сайжирч , тоосжилт буурч ,иргэдэд таатай орчинтой ногоон цэцэрлэг бий болно
- Хөрсний элэгдэл урт хугацаанд тодорхой хувиар буурна.
- Орон нутгийн бичил уур амьсгал сайжирна.
- Экологийн сөрөг нөлөөллийг бууруулахад хувь нэмрээ оруулна
- Орон нутгийн иргэдийн байгаль хамгаалах ухамсар дээшилнэ

Төслийн шинэ санааг урьдчилан үнэлэх нь: Манай төслийн санаа нь сумын төвийн төв талбайд зам ,гудамж дагуу мод тарьж иргэдийн зорчих хэсэгт таатай орчныг бий болгох, сайжруулах зорилготой юм. Мэргэжлийн байгууллагын мод тарьж байгаа ажил нь сумын төвд , ойрхон ил тод ажиллаж байгаа нь үндсэндээ олон нийтэд зөв технологиор мод тарих сургалт болох юм. Байгууллага хамт олноороо нэгдэн мод тарьж ,цэцэрлэг байгуулах нь хамтач болох, иргэд ,хүүхдүүдэд үлгэр дууриал болох ,хөдөлмөрт шамдах сэтгэлгээ суулгах зэрэг нийгэмд эерэг нөлөөлөл үзүүлэх цаг үетэйгээ тохирсон хамгийн сонгомол "Ногоон төгөл" төсөл гэж үзэж байна. Байгалийн тэнцвэрт байдлыг хангахад томоохон ач холбогдолтой , сайн нөлөөлөл үзүүлдэг мод тарих аян нь иргэдийн эрүүл аюулгүй амьдрах амьдралын баталгаа , агаар цэнгэг ,цэвэр бол халдварт өвчин, хорт нян бактери үүсэх нөхцөлөөс сэргийлэх онцгой ач тустай юм. Нийгмийн болон иргэдийн ухамсар дээшилж зөв боловсон амьдралын хэв маяг илүү хөгжинө гэж үзэж байна. Мөн төрийн баримталж буй бодлого шийдвэр, "Тэр бум мод " үндэсний хөтөлбөр , "Ногоон Дархан -2032 " төсөл хөтөлбөрийн хэрэгжилтэнд богино хугацаанд бодит хувь нэмэр болно.

Бид ирээдүйн үнэ цэнийг нь тооцоолж холимог төрлийн шилмүүст ховор мод , тансаг үнэрт унаган моднууд , цэцэгт навчит моднуудыг сонгож тарих юм. Мод тарихад зардал их өндөр гарна, бид өөрийн төрөлх сумандаа нийгмийн хариуцлагаа ухамсарлаж зарим зардлуудыг компаниас гаргах , мөн хамтын хүчээр шийднэ гэж зорьж байна. 2 , 3 дах жилийн арчилгааны зардал энэ тооцоололд тусгагдаагүй болно.

ТӨСЛИЙН ЭДИЙН ЗАСГИЙН ТООЦОО

Төсөлд шаардагдах тоног төхөөрөмж, хөрөнгө оруулалтын тооцоог дараах хүснэгтээр харуулав. Домогт Шарынгол ХХК нь өөрсдийн мод үржүүлгийн газарт үрээр тарьж ургуулсан өсөлтийн насанд хүрсэн 8-10 насны том бортоготой моднуудаа тарьж өгнө.

Суулгацны үнэ, зардал

1	Шинэс	ширхэг	10	120 000	1200 000
2	Гацуур	ширхэг	10	150000	1500 000
3	Нарс	ширхэг	10	150000	1500 000
4	Жодоо	ширхэг	10	300000	3000 000
5	Монос	ширхэг	5	80000	400 000
6	Голт бор	ширхэг	5	50000	250 000
Дүн					7850 000

Хашаажуулалтын зардал /0.5 га талбай/

1	Төмөр хашааны тор	0.5 га	Иж бүрдэл	4350 000	4350 000
2	Төмөр шон				
3	Төмөр хаалга				
4	Ажиллах хүч				Өөрсдийн хүчээр ажиллана.
Нийт дүн					4350 000

Төслийн зардлын тооцоо

1	Суулгацны үнэ	мян.төг	7850 000
2	Хашаажуулалтын зардал	мян.төг	4350 000
3	Техник, багаж төхөөрөмж	мян.төг	Өөрсдийн нөөц боломжоор
4	Усалгааны зардал, эхний жил, дараагийн 2 жил	мян.төг	Өөрсдийн нөөц боломжоор
5	Мод тарих ажиллах хүчний цалин хөлс		Өөрсдийн нөөц боломжоор
6	Х.Хын зардал бээлий, маск гэх мэт		Өөрсдийн нөөцөөс
Нийт Дүн			12200 000₮